



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/224

Хэрлэн сум

Хүүхдийн өрөө тохижуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу “Хүүхдэд ээлтэй орон нутаг болно” зорилтын хүрээнд Бор-Өндөр сумын Сум дундын цагдаагийн хэлтэст “Хүүхдээс мэдүүлэг авах өрөө” стандартад нийцүүлж тохижуулах зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Хөрөнгө зарцуулсан тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 25-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

**“НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНЭЭС МЭДҮҮЛЭГ АВАХ”,
“ХҮҮХДЭД ЧИГЛЭСЭН НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ” ӨРӨӨГ
ТОХИЖУУЛАХАД ШААРДАГДАХ ЗҮЙЛС**

д/д	Шаардлагатай эд зүйлсийн нэр	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сандал (бага насны хүүхэд суухад зориулагдсан)	2	50.000	100.000
2	Буйдан (хоёр хүн суух зориулалттай суудлын)	1	1.900.000	1.900.000
Нийт шаардагдах зардал				2.000.000